



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн **Эрүүл мэндийн эдийн засаг, бодлогын судалгааны албаны даргын ажлын байрны сонгон шалгаруулалтад оролцохыг урьж** байна.

Гүйцэтгэх үүрэг:

- Эрүүл мэндийн тулгамдсан асуудал, нийгмийн эрүүл мэнд болон эмнэлгийн тусламж үйлчилгээний бодлогод дэмжлэг үзүүлэх судалгаа хийх, мэдээний сан бүрдүүлэх
- Эрүүл мэндийн байгууллагын эдийн засаг, санхүүжилтийн дүн шинжилгээ, эрүүл мэндийн үндэсний тооцооны судалгаа хийх
- Эрүүл мэндийн салбарт ашиглагдаж буй технологид дүн шинжилгээ хийх
- Шийдвэр гаргагчдыг нотолгоот мэдээллээр хангах ажиллагааг зохион байгуулж, арга зүй, нэгдсэн зохицуулалтаар хангах

Тавигдах шаардлага:

- Анагаах ухаан, Нийгмийн эрүүл мэнд, Эдийн засаг, Статистик чиглэлээр магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх
- Төрийн албанд 5-аас доошгүй жил, удирдах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх
- Англи хэлний зохих түвшний мэдлэгтэй байх
- Дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, багаар ажиллах ур чадвартай байх
- Шударга, ёс зүйтэй, зарчимч байх
- Эерэг харилцаа, хандлагатай байх

Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет
- Их дээд сургууль төгссөн мэргэжлийн дипломын хуулбар (нотариатаар баталгаажуулах)
- Мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан бол гэрчилгээний хуулбар
- Иргэний үнэмлэхийн хуулбар
- Ажилд орохыг хүссэн өргөдөл
- 3x4 цээж зураг - 2%

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй иргэдийн материалыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Сүхбаатар Дүүрэг, 1-р хороо, Энхтайвны гудамж-13Б)-ийн 1 дүгээр байр, 2 давхар, 203 тоот өрөөнд 2023 оны 10 сарын 27-ны өдөр хүртэл хугацаанд хүлээн авна.
Утас: 70128805

ЗАХИРГАА, САНХҮҮ, УДИРДЛАГЫН АЛБА

2023.10.13